



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2023 оны 09 сарын 21 өдөр

Дугаар 459

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.1, 6.4.2, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Авлигатай тэмцэх газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 6 нэрийн, нийт 279,388,237.00 (хоёр зуун далан есөн сая гурван зуун наян найман мянга хоёр зуун гучин долоон) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. Авлигатай тэмцэх газрын Тамгын хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар 3. Баасаннямд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө акталж данснаас хасах ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2023 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 09 дүгээр сарын 11-ны өдрийн
...459 дүгээр тогтоолын хавсралт

АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ,
АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Ашиглалтад орсон огноо	Тоо хэмжээ (ширхэг)	Нэг бүрийн балансын үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)
1	Хэвлэл-4 өнгийн офсет машин DH452	2010-12-31	1	232,690,098.00	232,690,098.00
2	Хэвлэл-үдээсний машин	2010-12-31	1	10,121,823.00	10,121,823.00
3	Хэвлэл-Офсет хэвлэлийн машин DH56	2010-12-31	1	15,430,740.00	15,430,740.00
4	Хэвлэл-Хавтаслах төхөөрөмж KDFM720	2010-12-31	1	6,694,323.00	6,694,323.00
5	Хэвлэл-Бар бэлтгэх машин	2010-12-31	1	1,062,592.00	1,062,592.00
6	Хэвлэл-Цаас зүсэх машин	2010-12-31	1	13,388,661.00	13,388,661.00
НИЙТ ДҮН			6		279,388,237.00 (хоёр зуун далан есөн сая гурван зуун наян найман мянга хоёр зуун гучин долоо)